



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 14/02

Арвайхээр сум

Г Нийтийн сонсгол зохион байгуулах тухай Г

Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын 2.4, 2.6-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд туссан II улиралд зохион байгуулагдах нийтийн сонсголын сэдэв, төрөл, тов болон сонсгол даргалагчийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн сонсголын товыг цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх, бусад холбогдох арга хэмжээг хариуцан зохион байгуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (С.Ундрах)-д даалгасугай.

ДАРГА

Т.НАРАНГАРАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн
14/02 дугаар тогтоолын хавсралт

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2026 оны II улиралд
зохион байгуулах нийтийн сонсголын тов. сэдэв

№	Сонсголын сэдэв	Сонсголын төрөл	Сонсголын тов	Сонсгол даргалагч
1	2	3	4	5
1	Аймгийн ИТХ-ын 2023 оны “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай” 22/02 дугаар тогтоолын хэрэгжилт	Ерөнхий хяналтын сонсгол	2026.04.30-ны өдрийн Пүрэв гарагийн 09:00 цагт	Төсөв, эдийн засгийн бодлогын хорооны дарга О.Сумъяасүрэн
2	“Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл, үр дүн”	Төсвийн хяналтын сонсгол	2026.04.30-ны өдрийн Пүрэв гарагийн 14:00 цагт	Төсөв, эдийн засгийн бодлогын хорооны дарга О.Сумъяасүрэн
3	Аймгийн ИТХ-ын 2019 оны “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам батлах тухай” 11/01 дүгээр тогтоолын хэрэгжилт	Ерөнхий хяналтын сонсгол	2026.05.01-ний өдрийн Баасан гарагийн 11:00 цагт	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хорооны гишүүн Б.Ууганбаяр

